

Ноолуурын тогтвортой төсөл Мэтгэлцээн

I-р хэсэг: Сонирхогч талын даалгавар ба бэлтгэл

Энэ дасгал сурагчдад экологийн иймэрхүү асуудал ямар нарийн төвөгтэй байж болохыг ойлгоход нь тусална. Ноолуурын тогтвортой төсөлд оролцож буй сонирхогч талын байр суурийг баримтлан, тэдний үзэл бодлыг хамгаалан мэтгэлцсэнээр сурагчид хэлэлцүүлгийг өөриймсүүлж эзэмших болно. Түүнчлэн, янз бүрийн үзэл бодлыг харьцуулснаар сурагчид эрдэм шинжилгээний ажлын салбар хоорондын талыг харах болно.

Зорилт:

- Ноолуурын тогтвортой төсөлд оролцож буй өөр өөр сонирхогч талын санаа бодлыг ойлгох
- Томоохон хэмжээний экологийн санаачилгыг төлөвлөж, гүйцэтгэхэд гарч болох нарийн төвөгтэй асуудлыг тодруулах.

Материал:

- [Сонирхогч талын үзэл бодлын талаарх тараах материал](#)
- [Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудас](#)
- Цаг

Процесс:

- 1) Энэ төслийн хүрээнд "WCS Mongolia" байгууллагын зохицуулдаг Ноолуурын тогтвортой төсөлд оролцож буй сонирхогч талуудын дүрийг сурагчдад хуваарилна. Дүрүүд нь:
 - a) Ямаачин
 - b) Байгаль орчныг хамгаалах судлаач мэргэжилтэн
 - c) Загвар зохион бүтээгч
 - d) Нэхмэлийн үйлдвэрийн эзэн
 - e) Олборлох салбарын төлөөлөгч
 - f) Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Яамны СайдИлүү дэлгэрэнгүй мэдээллийг сонирхогч талын танилцуулгын тараах материалаас олж авах боломжтой
- 2) Хичээл дээр Монголын талын ажилтнуудын ярихыг сонсохын тулд Ноолуурын тогтвортой төслийн сонирхогч талуудын дүрс бичлэгийг үзнэ. Энэ нь бодит нөхцөл байдлыг танилцуулж, улмаар хэлэлцүүлгийн хүрээг ойлгоход нь сурагчдад тусална.
- 3) Багш нар сонирхогч талуудын дүрд сурагчдыг ганцаарчлан эсвэл хосоор нь хуваарилж, Сонирхогч талын үзэл бодлын тухай материал тараана.

- 4) Судалгаа хийж, удахгүй болох орон нутгийн хэлэлцүүлэгт бэлтгэх цаг өгнө. Энэхүү хэлэлцүүлэг нь ноолуурын худалдааны салбарт ашиг сонирхол бүхий талуудын хооронд зөвшилцөл бий болгоход туслах зорилготой. Одоогоор аль ч тал тус салбарт бүрэн дүүрэн сэтгэл хангалуун бус байгаа бөгөөд сонирхогч тал бүрийн баримталж буй өвөрмөц байр суурь нь бусадтайгаа зөрчилдөж байгаа юм.
- а) Сурагчдын зорилго нь сонирхогч талын хувьд хамгийн ашигтай байр суурийг хамгаалахад оршино. Тэд зөвшилцөж буулт хийх ёстой ч гол нь хэлэлцүүлгээс аль болох их зүйлийг олж авах шаардлагатай.
- 5) Хэлэлцүүлэгт оролцох төлөвлөгөө гаргахдаа Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудасны нэгдүгээр алхмыг хэрэглэхийг сурагчдад зааварла. Тэгээд зорилгоо тогтоож эхлэхийг даалгаарай!
- 6) Ноолуурын тогтвортой төслийн мэтгэлцээний 2-р хэсэг рүү шилжихээс өмнө сурагчдад Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудсан дээрээ ажиллах цаг олго.

 WCS presents

FIELD SIGHT

"WCS Education" болон манай байгалийн
цогцолборт газрын хөтөлбөрийн талаар
мэдээлэлт олж авахыг хүсвэл
wcs.org/education хаягаар орж үзнэ үү

 @WCSEducation

 @WCSEducation